



ЖИЛИЙН ТАЙЛАН

2025

АГУУЛГА

1 Удиртгал

Бидний тухай
Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлс
Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

2 Онцлох үйл явдал

3 Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигч
Төлөөлөн удирдах зөвлөл
Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод
Гүйцэтгэх удирдлага
Бүтэц, зохион байгуулалт

4 Голлох үзүүлэлтүүд

5 Даатгалын үйл ажиллагаа

Байгууллагын даатгал
Иргэдийн даатгал
Даатгагчийн баталгаа
Давхар даатгал
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

6 Нөхөн төлбөрийн үйл ажиллагаа

7 Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа

8 Хүний нөөцийн удирдлага

9 Тогтвортой хөгжил, Нийгмийн хариуцлага

10 Хамтын ажиллагаа

11 Аудитлагдсан санхүүгийн тайлан

БИДНИЙ ТУХАЙ

Иншүрко даатгал ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Иншүрко ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 94 дүгээр тогтоолоор ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Манай компани нь харилцагчдынхаа итгэл, найдвартай байдлыг нэн тэргүүнд эрхэмлэн, олон улсын жишиг, стандартад нийцсэн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, түүнчлэн эрсдэлийг оновчтой удирдах, санхүүгийн хамгаалалтыг бүрдүүлэх замаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа, амьдралын тогтвортой байдалд бодитой хувь нэмэр оруулахыг зорилгоо болгон ажиллаж байна.

Иншүрко даатгал ХХК нь үйл ажиллагаандаа дэвшилтэт технологи, дижитал шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлж, харилцагчиддаа илүү хялбар, түргэн шуурхай, уян хатан даатгалын

үйлчилгээг хүргэхэд анхаарч байна. Үүний зэрэгцээ бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, процессын үр ашгийг сайжруулах, мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах чиглэлд тасралтгүй ахиц гарган ажиллаж байна.

Мөн бид тогтвортой хөгжлийн зарчмыг үйл ажиллагаандаа баримтлан, нийгэм, байгаль орчинд ээлтэй бодлого, санаачилгуудыг дэмжих, хариуцлагатай бизнесийн зарчмыг хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдол өгч, компанийн засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх замаар урт хугацааны тогтвортой өсөлт, найдвартай ажиллагааг хангахыг зорьж байна.

Цаашид Иншүрко даатгал ХХК нь даатгалын салбарын хөгжилд манлайлан оролцож, харилцагчид болон хамтран ажиллагч, түнш байгууллагуудынхаа урт хугацааны найдвартай түнш байх, даатгалын салбарт итгэл даасан, хариуцлагатай байгууллага болон төлөвших зорилтоо тууштай хэрэгжүүлэх болно.



Тогтвортой хөгжил
Хамгаалалт
Хариуцлага
Итгэлцэл

ҮНЭТ ЗҮЙЛ



АЛСЫН ХАРАА

Даатгуулагчийн эрсдэлийг бууруулсан, олон улсын жишигт нийцсэн даатгалын цогц үйлчилгээ үзүүлж, баялаг бүтээгч хүн бүрийн хамгийн итгэлтэй, зорилтот сонголт байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн даатгалын цогц үйлчилгээ.

ИТГЭЛЦЭЛ

Итгэлцэл нь харилцан ойлголцол, хүндлэл, шударга зарчимд тулгуурласан харилцаа юм. “Иншүрко Даатгал” ХХК нь харилцагч болон ажилтнуудын итгэлийг эрхэмлэн хамгаалж, түүнийг тууштай хадгалахыг үйл ажиллагааныхаа үндсэн үнэт зүйл болгон ажилладаг.

ХАМГААЛАЛТ

Бид харилцагч болон ажилтнуудын нийгмийн аюулгүй байдал, хамгаалалтыг нэн тэргүүнд тавьж, болзошгүй эрсдэл, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэхэд анхаардаг. Нийгмийн хамгааллыг бид байгууллагын үндсэн үнэт зүйлсийн нэг болгон эрхэмлэн ажилладаг.

ХАРИУЦЛАГА

Хариуцлага нь ёс зүй болон шударга байдлын зарчимд тулгуурладаг. Манай компани хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх, гэрээний үүргээ цаг хугацаанд нь, зохих ёсоор биелүүлэхийг тууштай эрхэмлэн ажилладаг.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Итгэлцэл, хариуцлага болон хамгааллын зарчимд тулгуурлан бид харилцагчид, ажилтнууд, компани болон нийгэм, эдийн засгийн тогтвортой урт хугацааны хөгжлийн төлөө үе шаттайгаар тууштай ажиллаж байна.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



НАВААНСАМДАН ГАНБЯМБА



Иншүрко даатгал ХХК-ийн эрхэм харилцагчид, хамтран ажиллагч байгууллагууд, компанийн нийт удирдлага, ажилтан албан хаагчид та бүхний амар мэндийг эрэн мэндчилж байна.

2025 онд даатгалын салбар төдийгүй улсын эдийн засгийн орчинд гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхой сорилтуудтай зэрэгцэн шинэ боломжуудыг авчирсан онцгой жил байлаа.

Бид бизнесийн тогтвортой өсөлтийг хадгалах, санхүүгийн сахилга бат, эрсдэлийн оновчтой удирдлагыг

хэрэгжүүлэх, харилцагчийн эрх ашиг, итгэлийг нэн тэргүүнд тавих бодлогыг тууштай баримтлан ажилласан нь бидний хувьд чухал ололт амжилт боллоо.

Манай хамт олон бодлого, стратегийн зорилгоо бодит гүйцэтгэлтэй уялдуулан хэрэгжүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, харилцагчиддаа урт хугацааны үнэ цэн бий болгох чиглэлээр системтэйгээр ажилласны үр дүнд зах зээл дэх байр сууриа бэхжүүлж чадлаа.

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн засаглалыг сайжруулах, ил тод, хариуцлагатай, үр ашигтай удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх, компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, шийдвэрүүдийг дэмжин, хяналт тавин ажиллав. Үүний зэрэгцээ дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, нийцлийн шаардлагыг хангахад онцгой анхаарал хандууллаа.

Мөн дижитал шилжилтийг эрчимжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний инновац, харилцагч төвтэй шийдлүүдийг үе шаттайгаар нэвтрүүлэх суурь нөхцөл

бүрдсэн нь компанийн дунд болон урт хугацааны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал алхам боллоо хэмээн бид дүгнэж байна.

Эдгээр ололт амжилтыг бий болгоход бодитой хувь нэмэр оруулсан гүйцэтгэх удирдлагын баг, хариуцлагатай, чадварлаг нийт ажилтан, хамтран ажилласан эрхэм харилцагчид, хамтран ажиллагч, түнш байгууллагууддаа Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Цаашид Иншүрко даатгал ХХК нь харилцагчийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжил, хариуцлагатай засаглалыг эрхэмлэсэн бодлогоо тууштай хэрэгжүүлж, даатгалын салбартаа итгэл даасан, найдвартай байгууллага байх зорилгоо улам бүр бататган ажиллах болно.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, ажлын өндөр амжилт хүсье.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



БЯМБАДОРЖ СОЛОНГО

Иншүрко даатгал ХХК-ийн эрхэм харилцагчид, хамтран ажиллагч байгууллагууд та бүхэнд 2025 оны үйл ажиллагааны жилийн тайланг хүргэж байна.

2025 он бол бидний хувьд үйл ажиллагааны үр ашиг, дотоод чадавх, харилцагчийн сэтгэл ханамжийг бодитоор ахиулахад анхаарч ажилласан, хариуцлага нэхсэн, бодит үр дүнгээр хэмжигдэх он байлаа.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны үр ашиг, харилцагчийн сэтгэл ханамжийг нэн

тэргүүнд тавьж, бизнесийн процессыг сайжруулах, хурд, ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлд онцгойлон анхаарч ажиллалаа. Үүний зэрэгцээ бүтээгдэхүүн үйлчилгээний бүтэц, нөхцөлийг бодит хэрэгцээнд нийцүүлэн сайжруулах, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлууд шат дараатай хэрэгжиж эхэллээ.


2025 онд бид дотоод нөөц боломжид тулгуурлан хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, багийн уялдаа холбоог сайжруулах, хариуцлагатай, мэргэшсэн боловсон хүчнийг төлөвшүүлэхэд анхаарч чадварлаг, тууштай хамт олныг бүрлүүлэн компанийн үнэт зүйл, соёлыг бодит ажил хэрэг болгож, харилцагч бүрт чанартай, найдвартай үйлчилгээг хүргэхэд гол хөдөлгөгч хүчин болж байна.

Түүнчлэн дижитал шийдлүүдийг үйл ажиллагаандаа үе шаттай нэвтрүүлэх, дотоод процессуудыг автоматжуулах, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, харилцагчдад түргэн шуурхай, найдвартай үйлчилгээг хүргэх суурь ажлууд эхэлсэн нь цаашдын үр ашиг, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал алхам болов.

Цаашид Иншүрко даатгал ХХК нь тогтвортой өсөлт, үйл ажиллагааны өндөр гүйцэтгэл, харилцагч төвтэй үйлчилгээний жишиг стандартыг бий болгох зорилгоо хадгалан, илүү уян хатан, илүү шуурхай, илүү найдвартай даатгалын үйлчилгээ үзүүлэхийн төлөө ажиллах болно.

Бидэнд итгэл хүлээлгэн хамран ажилласан эрхэм харилцагчид, түнш байгууллагууддаа талархал дэвшүүлж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



2025 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



2025.03.20

Иншүрко даатгал ХХК нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авснаас хойш нэг жилийг амжилт бүтээлээр дүүрэн үдэж, ойн баяраа угтлаа.

2025.03.25

Даатгалын салбарын хамтын ажиллагаа, мэргэжлийн стандартыг бэхжүүлэх, салбарын хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилгын хүрээнд Албан журмын даатгагчдийн холбоонд гишүүнээр элсэв.



2025.06.20

Бид БОНЗ тайланг анх удаа боловсруулан тайлагнаж, тогтвортой хөгжил, ил тод байдлын чиглэлд шинэ алхам хийлээ.

2025.07.09

Тогтвортой хөгжлийн бодлого Монгол Улсын "Алсын хараа 2050", Монгол Улсын Ногоон Таксономи (ТоС Холбоо) болон олон улсын чиг хандлагатай уялдуулан 3 төрлийн ногоон даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүллээ.



2025.09.10

Аялал жуулчлалын салбарын хөгжил, хамтын ажиллагааг дэмжих зорилгын хүрээнд Монголын Аялал Жуулчлалын Холбоонд гишүүнээр элсэв.



2025.09.23

Аялал жуулчлалын холбооноос зохион байгуулсан OUTBOUND TRAVEL MART арга хэмжээнд амжилттай оролцож, гадаадад зорчигчийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар оролцогчдод дэлгэрэнгүй мэдээлэл хүргэв.



2025.10.11

Иншүрко Даатгал ХХК нь Хаан Банкнаас зохион байгуулсан Green Day – Family Day ногоон, байгальд ээлтэй хэрэглээг дэмжих өдөрлөгт Ногоон багц даатгалын бүтээгдэхүүнээрээ амжилттай оролцож, оролцогчдод холбогдох мэдээлэл, зөвлөгөө хүргэн ажиллалаа.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Иншүрко даатгал ХХК нь 100 хувийн дотоодын хөрөнгө оруулалттай ердийн даатгалын компани юм.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Иншүрко даатгал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, Компанийн засаглалын кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг чанд мөрдөн, компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлэхэд анхааран ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 5 гишүүнтэй бөгөөд 3 ердийн гишүүн, 2 хараат бус гишүүнээс бүрддэг бөгөөд гишүүд болон Нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад бүрэн хамрагдсан.

ТУЗ нь 2025 онд ээлжит болон ээлжит бусаар хуралдаж, дараах асуудлуудыг хэлэлцэн баталж, холбогдох тогтоол, шийдвэрүүдийг гарган ажиллав. Үүнд:

Даатгалын бүтээгдэхүүн зах зээлд борлуулах

Компанийн шинэчилсэн бүтэц, чиг үүрэг

Даатгалын орлогын шимтгэлийн дээд хувь хэмжээ

Даатгалын багц дүрмийн дагуу батлагдах шаардлагатай төлөвлөгөө

2026 оны бизнес төлөвлөгөө, төсөв

Компанийн засаглалын кодексийн хүрээнд батлагдах шаардлагатай бодлогын баримт бичиг, хөтөлбөр

2025 оны Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээ - **83.3** хувь

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Н.ГАНБЯМБА

ТУЗ-ийн дарга



Ш.ЖАРГАЛСАЙХАН

ТУЗ-ийн гишүүн



Б.СОЛОНГО

ТУЗ-ийн гишүүн



Д.ТӨМӨРЧӨДӨР

ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Г.ЯНЖМАА

ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Д.УЯНГА

ТУЗ-ийн Нарийн
бичгийн дарга

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ 3 хороотой бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон байдаг.

ТУЗ-ийн дэргэдэх хороод	Үндсэн чиг үүрэг	Бүтэц, бүрэлдэхүүн	
Аудит, эрсдэлийн удирдлагын хороо	Компанийн санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагаа, дотоод хяналтын системийн хэвийн үйл ажиллагаа, их дүнтэй болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл, дотоод аудитын үйл ажиллагаа, хууль, дүрэм журмын хэрэгжилтэд компанийн зүгээс хяналт тавих	Дарга Гишүүн Гишүүн	Ш.Жаргалсайхан Д.Төмөрчөдөр Г.Янжмаа
Хүний нөөц, нэр дэвшүүлэх хороо	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, тухайн шаардлагад нийцэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх	Дарга Гишүүн Гишүүн	Д.Төмөрчөдөр Н.Ганбямба Б.Солонго
Цалин урамшууллын хороо	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг боловсруулж, хяналт тавих, тэдгээрт олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах	Дарга Гишүүн Гишүүн	Г.Янжмаа Ш.Жаргалсайхан Н.Ганбямба

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ



Б.СОЛОНГО

Гүйцэтгэх захирал



Ө.ЭРХЭМБЯЯР

Даатгалын газрын
захирал



Я.ОТГОНДАВАА

Эрсдэл, нөхөн
төлбөрийн газрын
захирал



Д.УЯНГА

Үйл ажиллагааны
газрын захирал




А.АНАР

Санхүү удирдлагын
газрын захирал

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 07 дугаар 18-ны өдрийн 04 дугаар тогтоолоор бүтэц, чиг үүргийг шинэчлэн батлав.



БИДНИЙ 2025 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Нийт хөрөнгө

сая.төгрөг




Нийт хураамж

сая.төгрөг




Нөөц сан

сая.төгрөг




Нөхөн төлбөр

сая.төгрөг




Даатгуулагчдын тоо



Хөрөнгө оруулалтын орлого

сая.төгрөг





ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ


📈 Хураамжын орлого

1,440 тэрбум ₮

📄 Гэрээний тоо

67

Хураамжийн орлогод эзлэх хувь /хэлбэрээр/





XDrive 45

ИРГЭДИЙН ДААТГАЛ

ИРГЭДИЙН ДААТГАЛ


Хураамжын орлого

1,796 тэрбум ₮

Гэрээний тоо

15,026

Хураамжийн орлогод эзлэх хувь /хэлбэрээр/



ДААТГАГЧИЙН БАТАЛГАА

Монгол улсын Даатгалын тухай хуульд 2022 онд нэмэлт өөрчлөлт орсноор даатгалын компаниуд даатгагчийн баталгаа гаргах боломжтой болж, 2024 оноос үзүүлж эхэлсэн нь бизнесийн орчинд бодит өөрчлөлт авчирсан билээ.

Даатгагчийн баталгаа нь уламжлалт банкны баталгаа, батлан даалтын зарим хэрэгцээг орлох шинэ боломжийг бий болгож, санхүүгийн зах зээлийн бүтэц, хүртээмжийг тэлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Бид Даатгагчийн баталгааны зөвлөлд элсэж, Даатгагчийн баталгаа болох Тендерийн баталгаа, Гүйцэтгэлийн баталгаа, Урьдчилгаа төлбөрийн баталгаа, Чанарын баталгааг хууль журмын дагуу хийж байна.

2025 онд Иншүрко Даатгал ХХК нь Иргэний хуулийн 457 дугаар зүйл, Даатгалын тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 46 дугаар тогтоолоор нэмж баталсан "Даатгалын багц дүрэм"-ийн арван долоо дугаар хавсралт "Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журам"-г тус тус үндэслэн "Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-д зарлагдаж буй бүх төрлийн тендерт тендерийн баталгаа болон холбогдох бусад баталгааг амжилттай гаргасан байна. Тайлант онд нийт 7.26 тэрбум төгрөгний баталгаа гаргаснаас:

Тендерийн баталгаа

1.15 тэрбум төгрөг

Гүйцэтгэлийн баталгаа

3.35 тэрбум төгрөг

Урьдчилгаа төлбөрийн баталгаа

2.76 тэрбум төгрөг

ДАВХАР ДААТГАЛ

Бид тайлант онд “Үндэсний Давхар Даатгал” ХК-тай Трити гэрээ байгуулан үндсэн даатгалын багц бүтээгдэхүүнүүдийн эрсдэлийг хуваарилан хамтран ажиллаж байна.

Мөн Трити гэрээнээс гадна даатгалын үнэлгээ өндөр, хүлээгдэж буй хохирлын хэмжээ харьцангуй их байж болох даатгалын тохиолдолд тусгай нөхцөлтэй факультатив (нэг бүрчилсэн) давхар даатгалын хэлбэрээр олон улсын давхар даатгагч байгууллагуудтай хамтран ажиллалаа.

**CHUBB®** **SmartChoice**
Insurance intermediary service**XL Insurance
Reinsurance**

Эдгээр олон улсын давхар даатгагч байгууллагыг сонгохдоо манай компани дараах санхүүгийн болон зохицуулалтын шаардлагыг хангасан байх зарчмыг баримталж ажилладаг. Үүнд:

- Давхар даатгалын бодлогын хүрээнд эрсдэлийг шилжүүлж буй давхар даатгагчийн санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадварын үнэлгээнд тогтмол хяналт тавих, эрсдэлийн үнэлгээг судалгаа, тооцоололд үндэслэн хийдэг байх;
- Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос тухайн чиглэлээр авсан байх;
- Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний агентлагуудаас доорх доод түвшний зэрэглэлээс дээш үнэлгээтэй байх, ба үүнд:

A.M. Best агентлагийн үнэлгээ: “A”
түвшин ба түүнээс дээш;

Standard & Poor’s (S&P) болон Fitch
Group: “BBB” түвшин ба түүнээс дээш;

Moody’s Corporation: “Баа” түвшин ба
түүнээс дээш;

Rating Agency Expert RA: “A” түвшин ба
түүнээс дээш зэрэглэлийн үнэлгээтэй
байх.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Бид 2025 онд даатгалын бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлж, зах зээлд шинээр нэвтрүүлэх ажлыг эрчимтэй хэрэгжүүлж ажиллалаа.

Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороонд нийт 16 нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүний баримт бичгийн багц буюу:

Зах зээлийн судалгаа;
 Бүтээгдэхүүний дэлгэрэнгүй танилцуулга;
 Хураамжийн актуар тооцоолол;
 Даатгалын гэрээний төсөл, баталгаа зэрэг шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэн хүргүүлсэн байна.

Үр дүнд 12 төрлийн даатгалын бүтээгдэхүүн албан ёсоор зах зээлд борлуулагдах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авч компанийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн стратегийн хэрэгжилт, хууль эрх зүйн зохицуулалтад нийцсэн байдлыг бататгаж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, хэрэглэгч төвтэй шинэ бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлэх чухал алхам болов.



НОГООН ДААТГАЛЫН БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН



НОГООН ДААТГАЛЫН БАГЦ БҮТЭЭГДЭХҮҮН

Уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал нь хүн төрөлхтний өмнө тулгамдсан томоохон сорилт болж, байгаль орчны доройтол, цаг уурын гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдсээр байна. Монгол Улсын хувьд энэхүү нөлөөлөл илүү мэдрэгдэж, экосистемийн тэнцвэр алдагдах, эдийн засагт сөрөг үр дагавар үүсэх нөхцөл бүрдэж байна.

Ийм нөхцөлд байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, тогтвортой хэрэглээг дэмжсэн ногоон хөгжлийн шийдлүүд нь зөвхөн байгаль орчны төдийгүй эдийн засгийн хувьд өндөр ач холбогдолтой болж байна. Үүнтэй уялдан даатгалын салбар ч мөн шинэчлэгдэж, байгаль орчны эрсдэлийг бууруулахад чиглэсэн ногоон даатгалын бүтээгдэхүүнүүд хөгжиж байна.

Бид тогтвортой хөгжлийн бодлого Монгол Улсын "Алсын хараа 2050", Монгол Улсын Ногоон Таксономи (ТоС Холбоо) болон олон улсын чиг хандлагатай уялдуулан дараах 3 төрлийн ногоон даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэв. Үүнд:

НОГООН ЦАХИЛГААН БАРААНЫ ДААТГАЛ

Эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй цахилгаан хэрэгслийг хамарна.

Ухаалаг, инновацлаг төхөөрөмжүүдийг даатгалд хамруулах боломжтой.

Олон улсын стандарт (жишээ нь ENERGY STAR)-д нийцсэн бүтээгдэхүүнд чиглэнэ.

НОГООН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ДААТГАЛ

Эрчим хүч болон усны хэмнэлттэй шийдэл.

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ.

Эко материал, дэвшилтэт технологид суурилсан барилга байгууламж.

НОГООН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ

Цахилгаан болон гибрид тээврийн хэрэгслийг хамарна.

Шинэ технологид суурилсан (battery, software гэх мэт) эрсдэлийг тусгана.

Байгальд ээлтэй тээврийн хэрэглээг дэмжихэд чиглэнэ.

НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид даатгуулагчдадаа түргэн шуурхай, ил тод, найдвартай үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн нөхөн төлбөрийн үйлчилгээг бүрэн цахимжуулж байгууллага болон иргэдийн хүсэлтийг дунджаар 11 цагийн хугацаанд шийдвэрлэн ажиллав. Тайлант онд нийт 142 нөхөн төлбөрийг хууль, журмын дагуу шийдвэрлэн 138.7 сая төгрөгийг олгосон байна.

Нийт олгосон
нөхөн төлбөр

142

Нийт олгосон нөхөн
төлбөр (дүнгээр)

138.7 сая төгрөг

Байгууллагын даатгал
2995 сая төгрөг

Иргэдийн даатгал
108.7 сая төгрөг


Нөхөн төлбөр
шийдвэрлэсэн
дундаж хугацаа

1 өдөр



НӨХӨН ТӨЛБӨРИЙН ПРОЦЕСС

- ▼ Даатгалын тохиолдол үүсэх
- ▼ Иншүрко даатгал ХХК руу холбогдож даатгалын тохиолдлын талаар мэдээллэх
- ▼ Даатгалын тохиолдол нотолгоожуулах (Онлайн үзлэг болон биет үзлэг)
- ▼ Нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх (Цахимаар болон эх хувиар)
- ✓ Нөхөн төлбөрийн шийдвэрлэлт, олголт





**ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА**

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Даатгалын салбарын үйл ажиллагаа нь өөрийн онцлог бүхий бусдын эрсдэлийг өөртөө шилжүүлэн хүлээж авдаг бөгөөд үүний үр дүнд байгууллагын үйл ажиллагаанд мөн олон төрлийн эрсдэл үүсэх боломжтой байдаг.

Ирээдүйд юу тохиолдохыг урьдчилан гарцаагүй мэдэх боломжгүй байдлыг тодорхой бус байдал гэж үздэг. Тодорхой бус байдлаас эрсдэлийг тусад нь авч үзэх боломжгүй бөгөөд тодорхой бус байдал нь хүмүүсийн хөрөнгө, ашиг сонирхол эсвэл төлөвлөгөөнд сөргөөр нөлөөлөх үед эрсдэл болж илэрдэг. Компанийн эрсдэлийн удирдлага нь эрсдэлийг бууруулахад шаардагдах зардал болон үр ашгийг харгалзан, зохистой шийдвэр гаргах арга замыг тодорхойлох үйл явц юм.

Бид компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийг ерөнхийд нь дараах хоёр үндсэн төрөлд ангилан авч үздэг.

1. Даатгалын эрсдэл

Даатгалын бүтээгдэхүүнтэй холбоотой үндсэн эрсдлүүдийг хамрах бөгөөд эдгээрээс үүсэх боломжит хохирлыг Value at Risk (VaR) аргачлалаар үнэлнэ. Энэхүү арга нь тодорхой магадлалын түвшинд үүсч болох хамгийн их алдагдлыг хэмжих бөгөөд олон улсын Solvency II болон эрсдэлд суурилсан капитал (RBC)-ын тооцоололд өргөн хэрэглэгддэг.

2. Даатгалын бус эрсдэл

Үйл ажиллагааны, санхүүгийн, улс төрийн болон бусад бизнесийн эрсдэлүүдийг хамруулна. Эдгээрийг “Эрсдэлийн ангилал ба тодорхойлолт” аргачлалаар үнэлж, байгууллагын эрсдэл даах сонирхол (Risk Appetite)-ыг тодорхойлно. Тоон хэмжүүрээр үнэлэх боломжгүй эрсдэлийг үнэлгээнд үндэслэн индексжүүлж, өндөр эрсдэлийг бууруулах арга хэмжээг Эрсдэлийн хороо хэрэгжүүлнэ.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Иншүрко даатгал ХХК нь эрсдэлийн удирдлагыг тасралтгүй хэрэгжих, давтагдах процесс гэж үздэг бөгөөд дараах 5 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:



Эрсдэлийг тодорхойлох нь нийт ажилчдын үүрэг бөгөөд манай компанид үүсэж болох эрсдэл, түүний шинжилгээг бид бүхий л түвшний ажилчдад эрсдэлийн шинжээчийн зүгээс үнэлэх боломжийг бий болгон ажилладаг.

Уг үнэлгээгээр гарсан эрсдэлийг удирдах арга хэрэгслийг Эрсдэлийн хороо шийдвэрлэдэг бөгөөд арга хэрэгслийн хэрэгжилтэд Эрсдэлийн газар хяналт тавин жилдээ 2 удаа Эрсдэлийн хороонд тайлагнадаг байна. Манай компани эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх хамгаалалтын 3 шугамтай.

Хамгаалалтын нэгдүгээр шугам

Компанийн газар, нэгжийн бүх ажилтнууд

Хамгаалалтын хоёрдугаар шугам

Эрсдэл хариуцсан газар, хэлтэс

Хамгаалалтын гуравдугаар шугам

Эрсдэлийн хороо

ЭРСДЭЛГҮЙГЭЭР УРАГШИЛЪЯ



ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн хүний нөөцийн бодлого нь компанийн үнэт зүйл болох ажилтан бүрийн мэргэжил, ур чадварт тулгуурласан чадварлаг багийн ажиллагааг орчин үеийн хүний нөөцийн менежментийн аргатай хослуулж, бизнесийн урт хугацааны тогтвортой амжилтыг бий болгоход оршдог.

Бид даатгалын салбар төдийгүй банк санхүүгийн салбарын туршлага, ур чадвар бүхий мэргэжилтнүүдийг нэгтгэн, чадварлаг хүний нөөцөөр багаа бүрдүүлэн ажиллаж байна.

Нийт ажилтны тоо

23

Дундаж нас

30

Тогтворжилтын коэффициент

54%

Эмэгтэй ажилтны эзлэх хувь

56%

АЖИЛТНЫ СУРГАЛТ, ХӨГЖИЛ

2025 онд сургалт, хөгжлийн үйл ажиллагааны хүрээнд ажилтнуудын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхээс гадна эрсдэлийн удирдлага, үйлчилгээний чанар, байгууллагын соёл, дижитал чадавхийг цогцоор нь бэхжүүлэхэд чиглэж дараах сургалтуудад ажилчдыг хамруулан ажиллав.

Мэргэжлийн болон салбарын сургалтууд

- Даатгалын салбарын шинэ ажилтны мэргэшүүлэх цогц сургалт
- Даатгалын залилан, түүнээс хэрхэн хамгаалах
- Forensic Accounting in Business Interruption Insurance Claims
- Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын шинжилгээ
- Хохирол хэтрэлтийн багцын давхар даатгалын сургалт

Тогтвортой хөгжил, ESG чиглэлийн сургалт

- Sustainability Frameworks in Action: Sustainability Reporting / Тогтвортой байдлын хүрээний хэрэгжилт
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн санхүүжилтийн тухай код” (WeCode) – Үндэсний нээлт

Дижитал ур чадвар, үйл ажиллагааны үр ашиг

- Microsoft 365 Admin Center
- WOW үйлчилгээг нэвтрүүлэх нь





Байгууллагын соёл, дотоод хөгжил

- Байгууллагын соёл ба түүний ач холбогдол

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, УРАМШУУЛАЛ

Компанид гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллын тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлж, ажилтны хувь нэмэр, бодит үр дүнг үнэлэх зарчимд шилжин ажиллаж байна. Энэхүү тогтолцоо нь шударга өрсөлдөөнийг дэмжих, бүтээмжийг нэмэгдүүлэх, сайн гүйцэтгэлийг урамшуулахад чиглэгдсэн.

АЖИЛТНЫ ХАНГАМЖ, УРАМШУУЛАЛ



ХҮНИЙ НӨӨЦИЙН ИДЭВХИЖҮҮЛЭЛТ

Иншүрко даатгал ХХК нь эрүүл, аюулгүй, эерэг ажлын орчныг бүрдүүлэх, хамтын ажиллагаа, харилцан хүндэтгэсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд тогтмол анхаарч ирсэн билээ.

2025 онд дотоод харилцаа, багийн уялдаа холбоог дэмжих арга хэмжээнүүдийг зохион байгуулж, ажилтнуудын оролцоо, сэтгэл ханамжийг сайжруулахад чиглэсэн бодит алхмууд хийгдлээ.



Welcoming Summer Event

Зуны дэлгэр цагийг угтан, хамт олны уялдаа холбоог бэхжүүлэх, ажилтнуудын эерэг уур амьсгалыг дэмжих зорилгоор дотоод арга хэмжээг зохион байгууллаа.

Спортын тэмцээн

Ажилтнуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг дэмжихийн зэрэгцээ хамт олны уур амьсгал, багаар ажиллах чадварыг бэхжүүлсэн дотоод арга хэмжээг зохион байгуулав.



Намрын canvas өдөрлөг

Намрын улирлын хүрээнд хамт олноороо байгальд амарч, canvas зураг зурах бүтээлч үйл ажиллагаанд оролцон ажил, амралтыг хослуулсан үр өгөөжтэй арга хэмжээг зохион байгуулав.





1 жилийн ой

Бид 1 нас хүрч хамтдаа ойн баяраа тэмдэглэн өнгөрүүлэв.

Витаминжуулалтын аян

Ажилчдын эрүүл мэндийг дэмжих, ажлын стрессийг бууруулах, эрүүл амьдралын хэв маягийг таниулах үүднээс “Эрүүл ажилтан – Эрч хүчтэй байгууллага” уриан дор витаминжуулалтын аяныг зохион байгуулж, нийт ажилтнуудыг хамруулан амин дэмээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэв.



Хүүхдийн баярын арга хэмжээ

“Хүүхдийн баяр”-ийг тохиолдуулан ажилтнуудын хүүхдүүдэд зориулсан баярын арга хэмжээг амжилттай зохион байгуулж, хүүхэд бүрд инээмсэглэл бэлэглэсэн баярын уур амьсгалыг бүрдүүлэв.

Шинэ жилийн арга хэмжээ

2025 оны жилийн үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн дүгнэж, шинэ жилийн арга хэмжээг зохион байгуулан амжилт бүтээлээ хамтдаа тэмдэглэн өнгөрүүлэв.





ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

БОНЗ ТАЙЛАН

Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэлтэй сөрөг үр дагавар, тогтвортой хөгжилд тулгарах эрсдэлүүд эрчимжихийн хэрээр тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх нь нэн чухал болохыг зохицуулагчид, хөрөнгө оруулагчид, олон нийт ухамсарлан хүлээн зөвшөөрч тогтвортой хөгжлийн талаарх бодлого, санаачилгууд хурдацтай хөгжиж байгаа билээ.

Тогтвортой байдлын тайлагнал нь дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудын дагуу байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж байх байгууллагын дадал болж байна.

Иншүрко даатгал ХХК нь 2025 онд байгууллагын үйл ажиллагааны эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй нөлөөлөл буюу БОНЗ-ын тайланг Даатгалын бодлогын зөвлөлийн зөвлөмжийн дагуу заагдсан хугацаанд ил тод, анхны удаа амжилттай тайлагнан ажиллав.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Санхүүгийн Зохицуулах
Хороо, Монголын
Даатгалын Зах Зээлийн
Холбоо, Монголын
Даатгалын Холбоо болон
Монголын Даатгалын
Зуучлагчдын Холбоо нар
хамтран Тэрбум мод
төслийн хүрээнд
Үндэсний цэцэрлэгт
хүрээлэнд Даатгалын
салбарын нэрэмжит Шар
хуайсан төгөл бий
болгов.



Хүүхдийн баярыг
тохиолдуулан
Сонгинохайрхан дүүрэгт
байрлах “Эрдэм төв”
хүүхдийн асран
хамгаалах газрын хүүхэд
багачуудад хүүхдийн
баярын бэлэг болон тус
төвд шаардлагатай
хэрэглээний зүйлсийн
тусламжийг хүргүүлэв.
Тус үйл ажиллагаа нь
хайр халамж, итгэл
найдвар түгээх,
хүүхдүүдэд инээмсэглэл
бэлэглэх үнэтэй алхам
болсон билээ.



Монгол Улсын нийслэл
Улаанбаатар хотод анх
удаа “Улаанбаатар
биенналь-2025” соёлын
нэгдсэн үйл ажиллагаа
зохион байгуулагдаж 25
улсын 100 гаруй уран
бүтээлчид оролцсон нийт
15 үзэсгэлэн амжилттай
толилуулав. Иншүрко
даатгал ХХК-ийн зүгээс
БНСУ-ын удирдлагын баг,
куратор болон уран
бүтээлчдийг Монгол улсад
зорчих хугацаанд
Монголд аялагчийн иж
бүрэн даатгалд
хамруулав.



Сайн дурын дугуйн спортын залуучуудын БНХАУ руу зорьсон олон улсын аяллыг дэмжин ивээн тэтгэж, дэмжлэг үзүүлэн тэдний аюулгүй, амжилттай оролцоог хангахад хувь нэмэр оруулав.

Энэхүү санаачилгыг дэмжсэнээр залуучуудын эрүүл амьдралын хэв маяг, идэвхтэй хөдөлгөөнийг урамшуулахын зэрэгцээ тэсвэр хатуужил, багийн хамтын ажиллагаа, зорилгодоо хүрэх тэмүүллийг түгээн дэлгэрүүлэхэд бодит хувь нэмэр үзүүллээ.



REX functional fitness төвийн дасгал хөдөлгөөнийг эрүүл амьдралын хэв маяг болгосон залуучуудын тэсвэр тэвчээрийн асар том сорил болох гишүүдийн дундах UNITY GAMES 2025 тэмцээнд ивээн тэтгэгчээр хамтран ажиллалаа.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Иншүрко Даатгал” ХХК нь 2025 онд арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд (ББСБ) болон даатгалын брокерын байгууллагуудтай стратегийн түншлэл хөгжүүлэх, борлуулалтын сувгийг өргөжүүлэхээр хамтран ажиллаж байна. Эдгээр хамтын ажиллагаа нь харилцагчид болон даатгуулагчдад олон улсын жишигт нийцсэн даатгалын үйлчилгээг хүргэх, санхүүгийн байгууллагуудын зээлийн эрсдэлийг бууруулах, хамтын бизнесийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Түүнчлэн, 2025 онд шинээр 10 байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, түншлэлийн хүрээг өргөжүүлэн ажилласан байна. Үүнд:

БАНК



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА (ББСБ)



ДААТГАЛЫН БРОКЕР



ЭМНЭЛЭГ







**АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**



“СҮЛД-АУДИТ” ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ИНШҮРКО ДААТГАЛ” ХХК

***2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар
болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан***

Улаанбаатар хот

2026 он



СҮЛД-АУДИТ ХХК

Нягтлан бодох бүртгэл хяналтын итгэмжлэгдсэн
байгууллага

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Дүгнэлт

Бид “Иншүрко Даатгал” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (цаашид “Компани” гэх) 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Иншүрко Даатгал” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СҮЛД-АУДИТ ХХК

Ч.ГҮНДБАЯР
Захирал 2887655
ММНБ
2026 оны 3 дугаар сарын 25

Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
2025 ОНЫ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**


(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.1	Бэлэн мөнгө	150,280,000.00	306,158,224.21
1.1.2	Харилцахад байгаа мөнгө	60,754,034.92	122,506,617.21
1.1.3	Бусад санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө		
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	211,034,034.92	428,664,841.42
1.2	Даатгалын авлага		
1.2.1	Даатгалын хураамжийн авлага	79,740,220.00	578,362,183.28
1.2.2	Буруутай этгээдээс авах авлага		
1.2.3	Давхар даатгалаас авах авлага		
	Даатгалын авлагын дүн	79,740,220.00	578,362,183.28
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.3.1	Бусад авлага	118,739.32	15,478,000.72
	Бусад санхүүгийн хөрөнгийн нийт дүн	118,739.32	15,478,000.72
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө		
1.4.1	НДШ-ийн авлага, бусад татварын авлага		
1.4.2	ААНОАТ татварын авлага		
1.4.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	76,223,237.47	76,223,237.47
1.4.4	Бараа материал	34,057,500.00	
1.4.5	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	146,902,528.70	325,580,718.21
1.4.6	Өмчлөх бусад хөрөнгө		
	Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	257,183,266.17	401,803,955.68
1.5	Хөрөнгө оруулалт		
1.5.1	Хадгаламж, хадгаламжийн сертификат	5,051,240,004.06	5,522,893,825.53
1.5.2	Үнэт цаас		
	Хөрөнгө орлуулалтын дүн	5,051,240,004.06	5,522,893,825.53
1.6	Даатгалын хөрөнгө		
1.6.1	Хойшлогдсон давхар даатгалын хураамж		40,883,835.62
1.6.2	Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсэг		
1.6.3	Даатгалын орлогын хойшлогдсон шимтгэл		
	Даатгалын хөрөнгийн дүн		40,883,835.62
1.7	Үндсэн хөрөнгө/Цэвэр/	34,974,857.88	594,957,708.46
1.8	Биет бус хөрөнгө/Цэвэр/	14,116,666.64	8,066,666.60
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,648,407,788.99	7,591,111,017.31
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Даатгалын өглөг		
2.1.1.1	Даатгалын хураамжийн буцаалтын өглөг		2,896,632.30
2.1.1.3	Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	4,794,688.85	90,421,285.97
2.1.1.4	Давхар даатгагчид өгөх өглөг		152,201,829.04
	Даатгалын өглөгийн дүн	4,794,688.85	245,519,747.31
2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр		



<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>		<i>Сүлд-Аудит ХХК</i>	
2.1.2.1	Зээлийн өглөг, хүү		282,557,726.32
2.1.2.6	Бусад өр төлбөр	48,164,605.00	45,046,715.52
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	48,164,605.00	327,604,441.84
2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр		
2.1.3.1	Цалингийн өглөг	46,285.72	5,230,250.00
2.2.3.2	НДШ-ийн өглөг	12,695,961.59	22,855,437.79
2.1.3.3	ААНОАТатварын өглөг		
2.1.3.4	Хойшлогдсон татварын өглөг		
2.1.3.5	Урьдчилж орсон орлого		857,430.00
2.1.3.6	Нийгмийн хөгжлийн сангийн өр төлбөр		
2.1.3.11	Бусад санхүүгийн бус өр төлбөр	22,975,894.65	12,450,550.99
	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	35,718,141.96	41,393,668.78
2.1.4	Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	313,277,943.45	1,598,125,998.99
2.1.5	Хоёрдогч өглөг, хүү		
2.1.6	Нөхөн төлбөрийн нөөц сан		
2.1.6.1	Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	67,064,304.32	526,791,878.01
2.1.6.2	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	662,500.00	
2.1.6.3	Учирч болзошгүй хохирлын нөөц сан	90,084,783.73	309,083,384.05
2.1.6.4	Тусгай нөөц сан		
	Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	157,811,588.05	835,875,262.06
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	559,766,967.31	3,048,519,118.98
2.2	ЭЗДИЙН ӨМЧ		
2.2.1	Эздийн өмч	5,000,000,000.00	5,000,000,000.00
2.2.2	Эздийн өмчийн бусад хэсэг	197,000,000.00	577,000,000.00
2.2.3	Хуримтлагдсан ашиг/алдагдал	(108,359,178.32)	(1,034,408,101.67)
	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,088,640,821.68	4,542,591,898.33
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,648,407,788.99	7,591,111,017.31

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
 2025 ОНЫ ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

<i>(тогроогоор)</i>			
№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Даатгалын үйл ажиллагаа		
2	Даатгалын хураамжийн нийт орлого	472,939,269.06	3,235,419,521.55
3	Даатгалын хураамжийн буцаалт	(1,849,837.43)	(272,599,127.76)
4	Давхар даатгалын хураамжийн зардал		(312,333,712.06)
5	Даатгалын хураамжийн цэвэр орлого	471,089,431.63	2,650,486,681.73
6	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(313,277,943.45)	(1,284,848,055.54)
7	Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт		40,883,835.62
8	Орлогод тооцсон хураамж	157,811,488.18	1,406,522,461.81
9	Нийт нөхөн төлбөр	1,053,200.00	138,705,350.90
10	Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр		
11	Буруутай этгээдээс авах нөхөн төлбөр		
12	Нөхөн төлбөрийн цэвэр зардал	1,053,200.00	138,705,350.90
13	Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	67,726,804.32	459,065,073.69
14	Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт		
15	Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	90,084,783.73	218,998,600.32
16	Зардалд тооцсон нөхөн төлбөр	158,864,788.05	816,769,024.91
17	Даатгалын гэрээний зардал	(119,577,284.77)	(492,435,723.97)
18	Давхар даатгалын шимтгэлийн орлого		
19	Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(120,630,584.64)	97,317,712.93
20	Хүү, Эрхийн шимтгэлийн орлого	666,375,536.07	726,000,864.28
21	Бусад орлого		2,160,748.00
23	Ерөнхий ба удирдлагын зардал	628,755,257.69	1,526,030,647.90
24	Борлуулалт, маркетингийн зардал		55,653,706.53
25	Санхүүгийн зардал	196,100.00	27,609,724.03
26	Бусад зардал	34,738,455.96	69,634,083.66
27	Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарз		
28	Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз, гарз		
29	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(117,944,862.19)	(853,448,836.91)
30	Орлогын албан татварын зардал	(9,585,683.87)	72,600,086.44
31	Татварын дараах ашиг (алдагдал)	(108,359,178.32)	(926,048,923.35)
32	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг(алдагдал)		
33	Тайланг үеийн цэвэр ашиг (алдагдал)	(108,359,178.32)	(926,048,923.35)
34	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
35	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
36	Бусад		
37	Орлогын нийт дүн	(108,359,178.32)	(926,048,923.35)
38	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
 2025 ОНЫ ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

(тогроогоор)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	НТК	Тогтвортой байдлын сан	Эдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 01-р сарын 01 -ний үлдэгдэл	100,000.00					100,000.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
3	Залруулсан үлдэгдэл	100,000.00	-	-			100,000.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(108,359,178.32)	(108,359,178.32)
5	Бусад дэлгэрэнгүй орлого						
6	Өмчид гарсан өөрчлөлт	4,999,900,000.00			197,000,000.00		5,196,900,000.00
7	Зарласан ногдол ашиг						
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000,000,000.00			197,000,000.00	(108,359,178.32)	5,088,640,821.68
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
11	Залруулсан үлдэгдэл	5,000,000,000.00			197,000,000.00	(108,359,178.32)	5,088,640,821.68
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					(926,048,923.35)	(926,048,923.35)
13	Бусад дэлгэрэнгүй орлого						
14	Өмчид гарсан өөрчлөлт				380,000,000.00		380,000,000.00
15	Зарласан ногдол ашиг						
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,000,000,000.00			577,000,000.00	(1,034,408,101.67)	4,542,591,898.33

Хавсаргасан тэмдэгтүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн сансугүй хэсэг болно



Санхүүгийн тайлангийн аудит

Сүлд-Аудит ХХК

**ИНШҮРКО ДААТГАЛ ХХК-ИЙН АУДИТ ХИЙСЭН
 2025 ОНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

(төгрөгөөр)


№	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	391,349,211.63	2,479,613,167.09
1.1.1	Даатгалын хураамжийн орлого	391,349,211.63	2,477,513,044.09
1.1.2	Бусад мөнгөн орлого		2,100,123.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	894,682,907.30	2,772,160,059.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн	315,475,684.85	739,689,121.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	87,692,127.68	204,016,093.95
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн	116,355,943.77	166,274,274.44
1.2.4	Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		160,131,883.02
1.2.5	Нөхөн төлбөрт төлсөн	1,053,200.00	138,705,350.91
1.2.6	Үүнээс: Сайн дурын даатгалын	1,053,200.00	138,705,350.91
1.2.7	Албан журмын даатгалын		
1.2.8	Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	46,475,607.14	56,755,782.26
1.2.9	Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	73,101,677.63	406,777,050.86
1.2.10	Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр		
1.2.11	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	190,000.00	12,771,963.73
1.2.12	Хүүний төлбөрт төлсөн		19,367,865.11
1.2.13	Татварын байгууллагад төлсөн	79,166,020.04	151,907,475.83
1.2.14	Даатгалын төлбөрт төлсөн		1,375,000.00
1.2.15	Бусад мөнгөн зарлага	175,172,646.19	714,388,198.57
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(503,333,695.67)	(292,546,892.71)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,306,398,763.81	729,184,495.28
2.1.1	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	5,640,023,227.74	
2.1.2	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		3,183,631.00
2.1.3	Хүлээн авсан хүүний орлого	666,375,536.07	726,000,864.28
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,789,031,033.22	695,681,366.38
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,835,360.00	389,523,403.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд	18,150,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	10,747,045,673.22	
2.2.4	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		306,157,963.38
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,482,632,269.41)	33,503,128.90
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,196,900,000.00	492,500,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		292,500,000.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас	4,999,900,000.00	
3.1.3	Бусад	197,000,000.00	200,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		15,825,429.69
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		9,942,273.68



*Санхүүгийн тайлангийн аудит**Сүлд-Аудит ХХК*

3.2.2	Бусад		5,883,156.01
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,196,900,000.00	476,674,570.31
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	210,934,034.92	217,630,806.50
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	100,000.00	211,034,034.92
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	211,034,034.92	428,664,841.42

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



ЭРСДЭЛГҮЙГЭЭР УРАГШИЛЪЯ




 Иншүрко Даатгал

 insurco.mn

 insurcodaatgal

 7711 1313

 info@insurco.mn

 Эко Интернэйшнл тауэр, 9 давхар, #901, #903